



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 07 сарын 28 өдөр

Дугаар а/130

Улаанбаатар хот

Заавар, маягт шинэчлэн батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15, 11.1.16, 11.1.19, 18 дугаар зүйлийн 18.2, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 2.1.3, 3.7.6, Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийн 5.3.3, Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 210 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааны заавар”-ыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд хөдөлгөөн хийхтэй холбоотой өргөдлийн бусад маягтын загвар”-ыг Хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тушаалыг хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авч бүртгэх, хянан шийдвэрлэх ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд хөдөлгөөн хийхтэй холбоотой үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Кадастрын хэлтэс /Д.Мөнхтамир/-т даалгасугай.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /М.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ашигт малтмал газрын даргын 2010 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 123, 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн а/07 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЦОГ

10 0892



**АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ХҮССЭН ӨРГӨДЛИЙГ БҮРТГЭХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР**

1116 128255

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. АМГТГ /цаашид “агентлаг” гэнэ/ нь Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан хуулийн этгээдийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр авахыг хүссэн өргөдлийг хүлээн авах, бүртгэх, түүнийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд Ашигт малтмалын тухай хууль тогтоомж болон энэхүү зааврыг баримтална.

1.2. Агентлаг нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр авахыг хүссэн өргөдлийн цахим дугаар олгох, өргөдлийг хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай явуулах нөхцөл, бололцоог бүрдүүлж ажиллана.

1.3. Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11-д заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг Монгол Улсын Засгийн газар тогтоох бөгөөд Засгийн газрын тогтоолд хамрагдсан талбайд гаргасан өргөдлийг хүлээн авч, бүртгэнэ.

1.4. Энэ зааврын 1.3-т заасны дагуу Засгийн газрын тогтоосон талбайгаас бусад талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэж гаргасан өргөдлийг хүлээн авч бүртгэхгүй.

1.5. Агентлагийн кадастрын асуудал хариуцсан нэгж /цаашид “кадастрын нэгж” гэх/ нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор Засгийн газраас тогтоосон талбайн мэдээллийг өдөр тутмын сонин, агентлагийн цахим хуудсаар нийтэд мэдээлж, ил тод, нээлттэйгээр зарлана.

**Хоёр. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн  
дугаарыг цахим системээр олгох**

2.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр авахыг хүссэн өргөдөл /цаашид өргөдөл гэнэ/ гаргах хүсэлттэй хуулийн этгээд ийнхүү өргөдөл гаргахаас өмнө кадастрын нэгжид энэ зааврын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягт /Маягт К-4/-ын дагуу хуулийн этгээдийн бүртгэлээ урьдчилан бүртгүүлнэ.

2.2. Өргөдлийн дугаар олгох цахим системд нэвтрэх эрхийн үйлчилгээний хөлсийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаалд заасны дагуу төлж, хуулийн этгээдийн цахим системд нэвтрэх бүртгэлийн кодыг авна.

2.3. Хуулийн этгээд энэ зааврын 2.2-т заасан бүртгэлийн кодоор өргөдлийн дугаар олгох цахим системд нэвтэрч өргөдлийн цахим дугаар авах бөгөөд өргөдөл гаргах огноог өдөр, цаг, минутын хамт тодорхой заасан хуудсыг өргөдлийн дугаар олгох цахим системээс хуулийн этгээдийн цахим шуудан /e-mail/-гийн хаягаар илгээнэ.

2.4. Өргөдлийн бүртгэлийн цахим дугаар олгох ажлыг зохион байгуулахаас 5-аас доошгүй хоногийн өмнө агентлагийн дарга тушаал гаргаж, агентлагийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.



2.5. Өргөдлийн дугаар олгох системд нэвтрэх эрхийн үйлчилгээний хөлс төлж бүртгүүлсэн боловч цахим дугаар олголтод оролцоогүй /цахим системд хандалт хийгээгүй/ тохиолдолд хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн үйлчилгээний хөлсийг дараагийн цахим дугаар олголтод шилжүүлэн тооцож болно.

### **Гурав. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч, бүртгэх**

3.1 Өргөдлийг хүлээн авч, бүртгэх, хянан шийдвэрлэх боломжит хугацааг харгалзан өргөдлийн бүртгэлийн цахим дугаар авсан эхний 600 хуулийн этгээдийн өргөдлийг кадастрын нэгж хүлээн авч, бүртгэнэ. Өргөдлийн бүртгэлийн нэг цахим дугаараар нэг өргөдөл гаргана.

3.2. Өргөдөл гаргах цахим дугаар авсан хуулийн этгээд нь энэ зааврын 2.3-д заасан хугацаанд өргөдлөө кадастрын нэгжид биечлэн ирж бүртгүүлэх бөгөөд өргөдөл бүртгүүлэх хугацаа өргөдөл тус бүрд 15 минутаас илүүгүй байна.

3.3. Өргөдөл гаргах цахим дугаар авсан хуулийн этгээд нь Ашигт малтмалын тухай хуулийн 18.2-т заасан баримт бичгийг энэ зааврын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягт /Маягт К-1/-ын дагуу өргөдөлд хавсаргасан байна.

3.4. Өргөдөл гаргах цахим дугаар авсан хуулийн этгээд нь өргөдөл гаргах талбайн солбицлыг урьдчилан бэлтгэж энэ зааврын 3.3-т заасны дагуу өргөдлөө бүртгүүлнэ.

3.5. Өргөдөл гаргах цахим дугаар авсан хуулийн этгээд нь кадастрын нэгжийн үйлчилгээний танхимд ирж Кадастрын бүртгэлийн систем /цаашид УУККС гэх/-ийг ашиглан өргөдөл гаргах талбайг сонгон солбицлоо тодорхойлж энэ зааврын 3.3-т заасан маягт болон талбайн зургийг хэвлэн авч өргөдлөө бүртгүүлж болно.

3.6. Кадастрын нэгжийн өргөдлийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн өргөдлийн бүртгэлийн цахим дугаарын дарааллын дагуу өргөдлийг хүлээн авч бүртгэн өргөдөлд хавсаргасан баримт бичгийн хуудас бүрийг дугаарлаж тэмдэг дарж баталгаажуулна.

3.7. Өргөдлийн бүртгэлийн цахим дугаар авсан хуулийн этгээд нь өргөдлийн маягт, хавсаргах баримт бичгийн хамт энэ зааврын 2.3-т заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй тохиолдолд өргөдөл гаргаагүйд тооцож тусгай бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

3.8. Кадастрын нэгж нь Ашигт малтмалын тухай хуулийн 18.2-т заасан шаардлага хангасан өргөдлийг хүлээн авах бөгөөд хэрэв шаардлага хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзан тусгай бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, өргөдөл гаргагчид энэ тухай тодорхойлолт гарган өгнө. Тодорхойлолтод өргөдлийг буцаах үндэслэлийг тодорхой дурдаж он, сар, өдөр, цаг, минут, хариуцсан мэргэжилтэн нэрээ гаргацтай бичнэ.

3.9. Кадастрын нэгжийн өргөдлийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн нь тухайн өдрийн хамгийн түрүүнд болон сүүлд бүртгэгдсэн өргөдөлд тусгай тэмдэглэгээ хийж, өргөдлийн бүртгэлийн тэмдэг дарна.

3.10. Кадастрын нэгж өргөдөлд хавсаргасан баримт бичиг нь эх хувиараа, эх хувийг хавсаргах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар хувь, үйлчилгээний хөлс төлсөн баримтыг эх хувиар нь хуулийн этгээдээс гаргуулан авна.



## **Дөрөв. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх**

4.1. Өргөдлийн дотоод хяналтын хуудаст холбогдох албан тушаалтан бүр өөрийн ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тухай тодорхой бичилт/өргөдлийг хянасан тухай тайлбар/-ийг холбогдох хүснэгтэд хийх бөгөөд, тэмдэглэл хийсэн огноог тавьж, гарын үсэг зурж баталгаажуулна.

4.2. Кадастрын нэгжийн өргөдлийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн нь хуулийн этгээдээс гаргасан хуулийн шаардлага хангасан, бүрдэл болсон өргөдлийг хүлээн авч УУККС-д бүртгэсний дараа өргөдөлд хавсаргасан баримт бичгийг хувийн хэрэг үүсгэн, дотоод хяналтын хуудас нээж кадастрын бүртгэлийн систем хариуцсан мэргэжилтэнд даруй шилжүүлнэ.

4.3. Кадастрын бүртгэлийн систем хариуцсан мэргэжилтэн уг өргөдлийг УУККС-д зөв бүртгэгдсэн эсэхийг хянан, дотоод хяналтын хуудаст зохих тэмдэглэл хийж, зураг зүйн бүртгэл хариуцсан мэргэжилтэнд тухайн ажлын өдөртөө багтаан шилжүүлнэ.

4.4. Зураг зүйн бүртгэл хариуцсан мэргэжилтэн нь өргөдлийг хүлээн авч Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-17.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх хэсэгт заасан шүүлтийг ажлын 2 өдрийн дотор багтаан энэ зааврын 4.4.1, 4.4.2-т заасны дагуу хийж гүйцэтгэн, хайгуулын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэнд өргөдлийг шилжүүлнэ:

4.4.1. хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн талбайн захын цэгүүдийг дөрвөн өнцөгт хэлбэрээр зураглалыг үйлдэж, тухайн талбайд өргөдлөөр олгох талбайг дүүргэлт хийсэн эсэхийг шалган зураг зүйн шүүлт хийнэ.

4.4.2. хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан талбайн хилтэй 30 см-ээс ихгүй, тухайн талбайтай давхцах давхцалын хэмжээ нь 1 гектараас ихгүй байдлаар зураг зүйн шүүлт хийнэ.

4.5. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл бүртгэснээс хойш тухайн өргөдөлд дурдсан солбицолд өөрчлөлт оруулахгүй болно.

4.6. Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан түрүүлж ирүүлсэн өргөдөл гэдэг нь мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан, өргөдөлд хавсаргасан баримт бичиг нь бүрэн гүйцэд түрүүлж ирүүлсэн өргөдөл байна. Түрүүлж ирүүлсэн өргөдөл нь Ашигт малтмалын тухай хуулийн 17.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд дараагийн бүртгүүлсэн хүчин төгөлдөр өргөдөл нь түрүүлж ирсэн өргөдөлд тооцогдоно.

4.7. Зураг зүйн шүүлтээр өргөдөлд тусгагдсан талбай нь Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1, 19.2.3-19.2.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн нь ажлын 5 өдөрт багтаан хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах тухай шийдвэр, мэдэгдлийн төслийг боловсруулан, эрх зүйн шүүлт хийлгэн харьяалах ахлах мэргэжилтнээр хянуулсны дараа Кадастрын нэгжийн дарга шийдвэр гаргаж, холбогдох мэдэгдлийг агентлагийн бичиг хэргээр дамжуулан өргөдөл гаргагчид хүргүүлнэ.



4.8. Өргөдөлд тусгагдсан талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой бол хайгуулын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн энэ талаар тухайн талбайн орших аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авах мэдэгдлийн төсөл (мэдэгдэлд саналын хуудас, талбайн зургийн хуулбарыг заавал хавсаргана)-ийг ажлын 3 өдрийн дотор багтаан боловсруулан харьяалах ахлах мэргэжилтнээр хянуулсны дараа Кадастрын нэгжийн даргаар гарын үсэг зуруулан баталгаажуулж, холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргад агентлагийн бичиг хэргээр дамжуулан хүргүүлнэ.

4.9. Мэдэгдэл явуулсан огноо, мэдэгдлийн дугаарыг УУККС-д бүртгэж, өргөдлийн хяналтын хуудаст тэмдэглэгээ хийнэ.

4.10. Аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн өргөдөлд хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг "дэмжсэн" санал ирүүлсэн тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн нь ажлын 3 өдрийн дотор багтаан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр, эхний жилийн төлбөр төлөх мэдэгдлийн төслийг боловсруулан, эрх зүйн шүүлт хийлгэн харьяалах ахлах мэргэжилтнээр хянуулсны дараа Кадастрын нэгжийн даргын шийдвэрийг гаргуулж, баталгаажуулна.

4.11. Аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн өргөдөлд хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан санал ирүүлсэн тохиолдолд тухайн санал нь Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, Монгол улсын дээд шүүхийн 2010 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 10-т заасан шаардлага болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хайгуулын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн хянан үзэж холбогдох шийдвэр, мэдэгдлийн төслийг боловсруулж, кадастрын нэгжийн даргаар хянуулж, дараах шийдвэрүүдийг гаргана:

4.11.1. Засаг даргын дэмжихгүй санал нь Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, Монгол улсын дээд шүүхийн 2010 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 10-т заасан шаардлага болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байвал ажлын 7 өдрийн дотор багтаан хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах шийдвэр, мэдэгдлийн төсөл боловсруулна.

4.11.2. Засаг даргын дэмжихгүй санал нь Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, Монгол улсын дээд шүүхийн 2010 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 10-т заасан шаардлага болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцээгүй байвал тусгай зөвшөөрөл олгох шийдвэр, мэдэгдлийн төсөл боловсруулна.

4.13. Энэ зааврын 4.11.1, 4.11.2-т заасан мэдэгдлийг агентлагийн бичиг хэргээр дамжуулан өргөдөл гаргагчид хүргүүлж, шийдвэрийг УУККС-д бүртгэн өргөдлийн хяналтын хуудаст тэмдэглэгээ хийнэ.

4.14. Аймаг, нийслэлийн Засаг даргад санал авах мэдэгдлийг баталгаат шуудангаар явуулсан өдрөөс хойш нийслэлд ажлын 5 хоног, орон нутагт ажлын 10 хоног өнгөрсний дараа мэдэгдлийг хүлээн авсанд тооцох бөгөөд энэ хугацаанаас хойш 30 хоногийн хугацааны дотор хариу ирүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 19.4-т заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн гэж үзэж, энэ зааврын 4.10-т заасны дагуу шийдвэрлэнэ.

4.15. Кадастрын нэгжийн даргын шийдвэрийн дагуу гарсан мэдэгдлийг өргөдөл гаргагчид агентлагийн бичиг хэргээр дамжуулан, эсвэл өргөдөл гаргагчид шууд гардуулах ба мэдэгдлийг хүргүүлсэн буюу гардуулсан хугацааг УУККС-д бүртгэн хяналтын хуудаст тэмдэглэгээ хийнэ. Мэдэгдлийг шуудангаар хүргүүлсэн бол



өргөдөл гаргагч мэдэгдлийг хүлээн авсан хугацааг Шуудангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан хугацаагаар тооцно.

4.16. Эхний жилийн төлбөр төлөх мэдэгдлийг өргөдөл гаргагч нь хүлээн авсан бол өргөдлийг хайгуулын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн нь тусгай зөвшөөрлийн төлбөр хариуцсан мэргэжилтэнд ажлын 1 өдрийн дотор багтаан шилжүүлнэ.


4.17. Өргөдөл гаргагч нь мэдэгдэлд заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн төлбөр болон хайгуулын тусгай зөвшөөрлийн эрх олгох үйлчилгээний хөлс/3 000 000 төгрөг/-ийг төлөөгүй, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр төлөх мэдэгдлийг 30 хоногийн дотор ирж аваагүй тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн нь ажлын 3 өдрийн дотор багтаан Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсэгт заасныг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг хүчингүй болгох тухай шийдвэр, мэдэгдлийн төсөл боловсруулан, эрх зүйн шүүлт хийлгэн харьяалах ахлах мэргэжилтнээр хянуулсны дараа Кадастрын нэгжийн даргын шийдвэр гаргах ба холбогдох мэдэгдлийг Агентлагийн бичиг хэргээр дамжуулан өргөдөл гаргагчид хүргүүлж УУХЫГ-д даруй бүртгэнэ.

4.18. Хайгуулын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн нь Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэгт заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон талаар холбогдох төрийн байгууллагуудад мэдэгдэж, өдөр тутмын сонинд мэдээлнэ.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ  
ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

АМГТГ-ын даргын *Х.Аюуш* оны *11* дугаар тушаалын  
Хоёрдугаар хавсралт



Маягт К-01

### ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо: .....(он/сар/өдөр)

Компанийн нэр: ..... Компанийн регистрийн дугаар: .....

Өргөдөл гаргагчийн нэр: ..... (Овог, нэр) Албан тушаал: .....

**Өргөдлийн талбай:**

Аймаг (хот) ..... Сум (дүүрэг) ..... Планшетын код .....

.....

.....

.....

..... га (хэмжээ) бүхий .....(газрын нэр) –д ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл авахын тулд өргөдөл гаргаж байна

Өргөдөл гаргасан талбай нь дараахь булангийн солбицлуудтай:

Цэгийн дугаар	Уртраг**			Өргөрөг**			Цэгийн дугаар	Уртраг**			Өргөрөг**		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1							11						
2							12						
3							13						
4							14						
5							15						
6							16						
7							17						
8							18						
9							19						
10							20						

Дараахь баримт бичгүүдийг хавсаргана уу:

- |   |                                                                                                        |                          |                          |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1 | Өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт (маягт К-04)                                                | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2 | Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (нотариатаар гэрчлүүлсэн)                                        | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3 | Өргөдөл гаргагчийн талбайн булангийн цэгүүдийн солбицол, байршил, хилийг харуулсан зураг (2 хувь)      | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4 | Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь)                                                             | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5 | Хайгуулын ажил эрхлэх мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан талаархи албан ёсны мэдээлэл (маягт К-18) | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 6 | Монгол Улсад татвар төлөгч болох тухай нотолгоо (татварын албанаас)                                    | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Тамга

Өргөдөл гаргагч: ..... /  
(Гарын үсэг)

(Нэр)

\* ус, газрын тос, байгалийн хий болон уран, торийн бүлэг, газрын ховор элементийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс бодисуудаас бусад ашигт малтмал

\*\* Газар зүйн солбицлуудыг WGS-84 солбицлын системийг ашиглан тодорхойлох ёстой





**АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо: .....(он/сар/өдөр) Хайгуулын тусгай зөвшөөрлийн дугаар: .....  
Компанийн нэр: ..... Компанийн регистрийн дугаар:.....  
Өргөдөл гаргагчийн нэр: ..... (Овог, нэр) Албан тушаал: .....

**Өргөдлийн талбай:**

Аймаг (хот) ..... Сум (дүүрэг) ..... Планшетиин код .....  
.....  
.....

..... га (хэмжээ) бүхий .....(газрын нэр) –д ашигт малтмал ашиглахыг хүсч өргөдөл гаргаж байна.

Ашигт малтмалын төрөл: .....  
Ашиглалтын талбай: ..... (хэсэгчлэн / бүхэлд нь)

Өргөдөл гаргасан талбай нь дараахь булангийн солбицлуудтай:

Цэгийн дугаар	Уртраг**			Өргөрөг**			Цэгийн дугаар	Уртраг**			Өргөрөг**		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1							11						
2							12						
3							13						
4							14						
5							15						
6							16						
7							17						
8							18						
9							19						
10							20						

**Дараахь баримт бичгүүдийг хавсаргана уу:**

- |                                                                                                                                                                                                                                                                                                  | Өргөдөл гаргагч хавсаргав | Өргөдөл хүлээн авагч хүлээн авав |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|----------------------------------|
| 1 Өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт (маягт КА-4)                                                                                                                                                                                                                                        | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 2 Монгол улсад татвар төлөгч болох тухай нотолгоо (харьяа татварын албаны)                                                                                                                                                                                                                       | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 3 Улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, дүрэм (нотариатаар гэрчлүүлсэн)                                                                                                                                                                     | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 4 Ашиглалт хийх болон үлдэх хайгуулын талбай тус бүрийн байршил, булангийн цэгүүдийн солбицол, хилийг буулгасан зураг (2 хувь)                                                                                                                                                                   | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 5 Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь)                                                                                                                                                                                                                                                     | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 6 Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээн авсан Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэр                                                                                                                                                            | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 7 Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр хүлээн авсан хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн нөөцийн дэвсгэр зураг дээр ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн талбайн хилийг буулгасан зураг. М1:1000, М1:5000, М1:10000 тохиромжтой масштабын дагуу (2 хувь) | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 8 Хайгуулын ажлын явцад Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт                                                                                                                                                                      | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 9 Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ                                                                                                                                                                                                                                                | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |
| 10 Хайгуулын тусгай зөвшөөрөл, хавсралтууд (эх хувь)                                                                                                                                                                                                                                             | <input type="checkbox"/>  | <input type="checkbox"/>         |

Тамга

Өргөдөл гаргагч: ..... /  
(Гарын үсэг)

/  
(Нэр)

\*\* Газар зүйн солбицлуудыг WGS-84 солбицлын системийг ашиглан тодорхойлох ёстой





МАЯГТ К-1/ К-2-ЫН ХАВСРАЛТ:

Өргөдөл гаргасан талбай нь дараахь булангийн солбицлуудтай:

Цэгийн дугаар	Уртраг*			Өргөрөг*			Цэгийн дугаар	Уртраг*			Өргөрөг*		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек

Тамга

Өргөдөл гаргагч: ..... /  
(Гарын үсэг) (Нэр) /

\* Газар зүйн солбицлуудыг WGS-84 солбилцлын системийг ашиглан тодорхойлох ёстой





Тодорхойлолтыг үнэн зөв бөглөж, улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм бусад шаардлагатай бичиг баримтын эх хувийн хамт ирүүлж бүртгүүлнэ үү.

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Хуулийн этгээдийн нэр: Монгол/Англи .....
2. Регистрийн дугаар: .....
3. Өмчийн хэлбэр:
 

Хувийн	<input type="checkbox"/>
Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой	<input type="checkbox"/>
Төрийн болон орон нутгийн өмчийн эзлэх хувь .....	

4. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн тоо:
 

Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн нэр:	Эзэмшдэг хувь:
.....	.....
.....	.....
.....	.....

5. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр:
 

.....

.....

6. Хуулийн этгээдийн хууль ёсны хаяг /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11.1.3-д заасны дагуу/:
 

Гудамж/байшин/, хаалганы дугаар: .....

Баг/ хороо: .....

Сум/ дүүрэг: .....

Аймаг/ хот: .....

Байршлын код: .....

Шуудангийн салбар/хайрцаг: .....

Утас:.....

Факс: .....

Гар утас: .....

Цахим шуудангийн хаяг: .....

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан:

Тамга ..... Эрх бүхий албан тушаалтны нэр  
/Гарын үсэг/ ..... /Нэр/

Тодорхойлолтыг хүлээн авч бүртгэсэн:

КХ-ийн тэмдэг ..... КХ-ийн /ахлах/ мэргэжилтэн  
/Гарын үсэг/ ..... /Нэр/

\*Энэхүү тодорхойлолтод өөрчлөлт орсон тухай бүр Кадастрын хэлтэст албан ёсоор мэдэгдэж, бүртгүүлэх бөгөөд буруу мэдээлэл бүртгүүлсэн болон өөрчлөлтийг бүртгүүлээгүйгээс үүсэх хариуцлагыг манай байгууллага хүлээхгүй болно.





**АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо: ..... (он/сар/өдөр)

Компанийн нэр: ..... Компанийн регистрийн дугаар:.....

**Тусгай зөвшөөрлийн шилжүүлэг:**

Шилжүүлгийн хэлбэр: ..... (хэсэгчилсэн /бүхэлд нь)

Шилжүүлэх тусгай зөвшөөрлийн дугаар: .....

Тусгай зөвшөөрлийг анх олгосон огноо: ..... (он/сар өдөр)

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шилжүүлэх хүсэлтийг ..... (итгэмжлэгдсэн төлөөлөгч)-д  
..... гаргав

Шилжүүлэх үндэслэл: .....  
.....  
.....

**Дараахь баримт бичгүүдийг хавсаргана уу:**

	Өргөдөл гаргагч хавсаргав	Өргөдөл хүлээн авагч хүлээн авав
1 Ашигт малтмалын тухай хуулийн 49.1, 49.3 дахь заалтад заасан тохиолдол үүссэнийг нотолсон нотолгоо /хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, тогтоол, компанийн дүрэм/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2 Шилжүүлж байгаа тусгай зөвшөөрөл, хавсралтууд; (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3 Шилжүүлж байгаа болон үлдэж байгаа талбайн тодорхойлолт(маягт К-10)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4 Шилжүүлж байгаа болон шилжүүлэн авч байгаа хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм, шилжүүлэх гэрээ (нотариатаар баталгаажуулсан байх)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5 Тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрч буйг нотлох баримт бичиг; (маягт К-7)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6 Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7 Тухайн талбайн олборлолт явуулсан хэсэгт нөхөн сэргээлт хийсэн тухай байгаль орчны хяналтын албаны тодорхойлолт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8 Байгаль орчныг нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг АМТ хуулийн 39.1.9-д заасан дансанд төвлөрүүлсэн тухай санхүүгийн баримт /тухайн жилийн барьцаа төлбөр/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9 Талбайн булангийн цэгүүдийн солбилцол, байршил, хилийг буулгасан зураг (2 хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10 Тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч буй хуулийн этгээдийн тухай тодорхойлолт (маягт К-9)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11 Тусгай зөвшөөрлийг шилжүүлж буй хуулийн этгээдийн тухай тодорхойлолт (маягт К-8)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12 Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээн авсан Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэр	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
13 Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр хүлээн авсан хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн нөөцийн дэвсгэр зураг дээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг /хэсэгчлэх шилжүүлэх/ хүссэн талбайн хилийг буулгасан зураг. М1:1000, М1:5000, М1:10000 тохиромжтой масштабын дагуу	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тамга

Өргөдөл гаргагч: .....

(Гарын үсэг)

(Нэр)

/





## ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо: ..... (он/сар/өдөр)

Компанийн нэр: ..... Компанийн регистрийн дугаар: .....

### Тусгай зөвшөөрлийн шилжүүлэг:

Шилжүүлгийн хэлбэр: ..... (хэсэгчилсэн /бүхэлд нь)

Шилжүүлэх тусгай зөвшөөрлийн дугаар: .....

Тусгай зөвшөөрлийг анх олгосон огноо: ..... (он/сар өдөр)

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шилжүүлэх хүсэлтийг ..... (итгэмжлэгдсэн төлөөлөгч)-д  
..... гаргав

Шилжүүлэх үндэслэл: .....

### Дараахь баримт бичгүүдийг хавсаргана уу:

	Өргөдөл гаргагч хавсаргав	Өргөдөл хүлээн авагч хүлээн авав
1 Ашигт малтмалын тухай хуулийн 49.1, 49.2 дахь заалтад заасан тохиолдол үүссэнийг нотолсон нотолгоо /хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, тогтоол, компанийн дүрэм/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2 Шилжүүлж байгаа тусгай зөвшөөрөл, хавсралтууд; (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3 Шилжүүлж байгаа болон үлдэж байгаа талбайн тодорхойлолт(маягт К-10)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4 Шилжүүлж байгаа болон шилжүүлэн авч байгаа хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, ААН-ийн дүрэм, шилжүүлэх гэрээ (нотариатаар гэрчлүүлсэн)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5 Тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрч буйг нотлох баримт бичиг; (маягт К-7)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6 Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7 Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг ирүүлж байсан талаарх баримт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8 Байгаль орчныг нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг АМТ хуулийн 38.1.8-д заасан дансанд төвлөрүүлсэн тухай санхүүгийн баримт /тухайн жилийн барьцаа төлбөр/	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9 Талбайн булангийн цэгүүдийн солбилцол, байршил, хилийг буулгасан зураг (2 хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10 Тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч буй хуулийн этгээдийн тухай тодорхойлолт (маягт К-9)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11 Тусгай зөвшөөрлийг шилжүүлж буй хуулийн этгээдийн тухай тодорхойлолт (маягт К-8)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тамга

Өргөдөл гаргагч: .....

(Гарын үсэг)

(Нэр)





**ГАРГАСАН ЗӨВШӨӨРЛИЙН  
НОТОЛГОО**

.....  
(шилжүүлэн авч буй хуулийн этгээд)

Огноо: ..... (он/сар/өдөр)

Шилжүүлэн авагчийн нэр: (шилжүүлэн авч буй хуулийн этгээд)..... (Овог, нэр)

Компанийн нэр: ..... Компанийн регистрийн дугаар: .....

**Тусгай зөвшөөрлийн шилжүүлэг:**

Тусгай зөвшөөрлийн дугаар: .....

Тусгай зөвшөөрлийг анх хүлээн авагч ..... (тусгай зөвшөөрлийн одоогийн эзэмшигч)

Анх олгосон огноо: ..... (он /сар /өдөр)

Дээр дурьдсан ашиглалт/ хайгуулын тусгай зөвшөөрлийг шилжүүлж авах хүсэлтэй байгаагаа батламжилж байна.

Тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авахдаа уг тусгай зөвшөөрлийг энэхүү нотолгоо гаргах үед эзэмшиж байгаа.....(тусгай зөвшөөрлийн одоогийн эзэмшигч) нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийнхээ хувьд Монгол улсын хууль тогтоомж болон энэхүү нотолгоо гаргахаас өмнө бусад этгээдтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж ирсэн талаар бүрэн дүүрэн ойлгож байна.

Иймд тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авмагц дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Ашигт малтмалын тухай хуульд заасан бүхий л үүргийг нь залгамжлан биелүүлэхээ бүрэн хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлж энэхүү нотолгоог гаргав.

Тамга

Нотолгоо гаргасан : ..... /

(Гарын үсэг)

/

(Нэр)

Тайлбар: Энэхүү нотолгоог зөвхөн тусгай зөвшөөрөл шилжүүлэн авч байгаа хуулийн этгээдийг бүрэн төлөөлөх хууль ёсны эрх бүхий этгээд гаргаж баталгаажуулна.





**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИЛЖҮҮЛЖ БУЙ  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ**

Хуулийн этгээдийн нэр: (эрх бүхий ажилтан байх шаардлагатай) .....

Захирлын нэр: ..... (Овог, нэр)

Албан ёсны харилцах:

Хаяг: .....

Шуудангийн салбар: ..... шуудангийн хайрцаг: .....

Утас: ..... Факс: ..... И\_мэйл: .....

Аж ахуйн нэгжийн хэлбэр:

Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/  
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ЗБН/  
Хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/  
Хувьцаат компани /ХК/  
ТӨҮГ, ТӨХК

Харгалзах тэмдэглэгээ

Уг тусгай зөвшөөрөл барьцаалагдсан эсэх:

тийм   
үгүй

Барьцаалагдсан бол тусгай зөвшөөрлийг барьцаалагч хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай албан ёсоор гаргасан тодорхойлолтыг хавсаргана.

Хувьцаа эзэмшигч:

..... / ..... / ( )

Гарын үсэг нэр хувь хэмжээ

..... / ..... / ( )

Гарын үсэг нэр хувь хэмжээ

..... / ..... / ( )

Гарын үсэг нэр хувь хэмжээ

/Олон хувьцаа эзэмшигчтэй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол хавсаргах/

Эцсийн шийдвэр гаргагч: ..... / /

Тамга

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан : .....

(Гарын үсэг)

(Нэр)





**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИЛЖҮҮЛЭН АВЧ БУЙ  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ**

Хуулийн этгээдийн нэр: (эрх бүхий ажилтан байх шаардлагатай) .....

Захирлын нэр: ..... (Овог, нэр)

Албан ёсны харилцах:

Хаяг: .....

Шуудангийн салбар: ..... шуудангийн хайрцаг: .....

Утас: ..... Факс: ..... И\_мэйл: .....

Аж ахуйн нэгжийн хэлбэр:

Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/  
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ЗБН/  
Хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/  
Хувьцаат компани /ХК/  
ТӨҮГ, ТӨХК

Харгалзах тэмдэглэгээ

Өмчийн хэлбэр:

100% хувийн  
төрийн өмчийн оролцоотой  
төрийн өмчийн эзлэх хувь .....

Харгалзах тэмдэглэгээ

Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан  
(байгууллага): .....

Хувьцаа эзэмшигч:

.....	/	/	( )
Гарын үсэг		нэр	хувь хэмжээ
.....	/	/	( )
Гарын үсэг		нэр	хувь хэмжээ
.....	/	/	( )
Гарын үсэг		нэр	хувь хэмжээ

/Олон хувьцаа эзэмшигчтэй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол хавсаргах/

Тамга

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан : ...../

(Гарын үсэг)

(Нэр)



**ШИЛЖҮҮЛЭХ/БУЦААН ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**Шилжүүлэх/буцаан хүлээлгэн өгөх талбай:**

Аймаг (хот) ..... Сум (дүүрэг) ..... Планшетийн код .....  
 .....  
 .....

Шилжүүлэх/буцаан хүлээлгэн өгөх талбай нь дараахь булангийн **солбицлуудтай:**

Цэгийн дугаар	Уртраг *			Өргөрөг *			Цэгийн дугаар	Уртраг *			Өргөрөг *		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1							11						
2							12						
3							13						
4							14						
5							15						
6							16						
7							17						
8							18						
9							19						
10							20						

**Үлдэж буй талбайн тодорхойлолт:**

Аймаг (хот) ..... Сум (дүүрэг) ..... Планшетийн код .....  
 .....  
 .....

Үлдэж буй талбай нь дараахь булангийн **солбицлуудтай:**

Цэгийн дугаар	Уртраг *			Өргөрөг *			Цэгийн дугаар	Уртраг *			Өргөрөг *		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1							11						
2							12						
3							13						
4							14						
5							15						
6							16						
7							17						
8							18						
9							19						
10							20						

Тамга

Тодорхойлолт гаргасан: .....

/Гарын үсэг/

/Нэр/





**ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА  
СУНГУУЛАХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо: ..... (он/сар/өдөр) Өргөдөл гаргагчийн нэр: ..... (Овог, нэр)  
Компанийн нэр: ..... Компанийн регистрийн дугаар: .....

**Тусгай зөвшөөрлийн талбай:**

Тусгай зөвшөөрлийн дугаар: .....

Хайгуулын талбай: .....(аймаг /хот)..... (сум /дүүрэг) .....(планшетын код)

Хэмжээ: .....га

Анх олгосон хугацаа: ..... (он/ сар /өдөр)

Сунгах хугацаа (зөвшөөрөгдөх дээд хугацаа 3 жил):

Хэзээнээс: ..... (он/ сар /өдөр)

Хэдий хүртэл: ..... (он/ сар /өдөр)

**Дараахь баримт бичгүүдийг хавсаргана уу:**

	Өргөдөл гаргагч хавсаргав	Өргөдөл хүлээн авагч хүлээн авав
1 Хайгуулын тусгай зөвшөөрөл, хавсралтууд, (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2 Тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөр төлсөн баримт (хавсралтанд баримтжаагүй бол төлбөрийн баримт тус бүрийн эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан тухай баримт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4 Хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс багагүй хэмжээний ажил гүйцэтгэсэн тухай болон хайгуулын тухайн үе шатны ажлыг гүйцэтгэсэн тухай тайлан, түүнийг хүлээлгэн өгсөн баримт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5 Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ (нотариатаар гэрчлүүлсэн)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тамга

Өргөдөл гаргагч: ..... /  
(Гарын үсэг)

..... /  
(Нэр)



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОГДСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙ ХЭСГИЙГ  
БУЦААЖ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо: ..... (он/сар/өдөр) Өргөдөл гаргагчийн нэр: ..... (Овог, нэр)  
Компанийн нэр: ..... Компанийн регистрийн дугаар: .....

**Тусгай зөвшөөрөл:**

Тусгай зөвшөөрлийн төрөл: ..... (хайгуул /ашиглалт)  
Тусгай зөвшөөрлийн дугаар: .....

Буцааж хүлээлгэн өгөх талбай: ..... (гектар)

Үлдэх талбай: ..... (гектар)

**Дараахь баримт бичгүүдийг хавсаргана уу:**

	Өргөдөл гаргагч хавсаргав	Өргөдөл хүлээн авагч хүлээн авав
1 Тусгай зөвшөөрөл, хавсралтууд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь буцааж хүлээлгэн өгөх талбайн хувьд байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тухай тухайн сум дүүргийн Засаг даргын болон байгаль орчны хяналтын албаны тодорхойлолт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3 Буцааж хүлээлгэн өгөх талбай тус бүрийн зураг тус бүр (1%), үлдэх талбай тус бүрийн зураг тус бүр (2%) (баталсан загварын дагуу)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4 Хайгуулын ажлын(уулын ажлын) төлөвлөгөө, тайлан өгч байсан талаарх тодорхойлолт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5 Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6 Талбайн тодорхойлолт (Маягт К-10)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7 Талбайн тодорхой хэсгийг буцаан хүлээлгэж өгөхийг зөвшөөрсөн хувь нийлүүлэгчийн хурлын шийдвэр	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ (нотариатаар гэрчлүүлсэн)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тамга

Өргөдөл гаргагч: ..... /  
(Гарын үсэг)

(Нэр)





**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОГДСОН ТАЛБАЙГ БҮХЭЛД НЬ  
БУЦААЖ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо: ..... (он/сар/өдөр) Өргөдөл гаргагчийн нэр: ..... (Овог, нэр)  
Компанийн нэр: ..... Компанийн регистрийн дугаар: .....

**Тусгай зөвшөөрөл:**

Тусгай зөвшөөрлийн төрөл: ..... (хайгуул /ашиглалт)  
Тусгай зөвшөөрлийн дугаар: .....

Буцааж хүлээлгэн өгөх талбай: ..... (гектар)

**Дараахь баримт бичгүүдийг хавсаргана уу:**

	Өргөдөл гаргагч хавсаргав	Өргөдөл хүлээн авагч хүлээн авав
1 Тусгай зөвшөөрөл, хавсралтууд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь буцааж хүлээлгэн өгөх талбайн хувьд байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тухай тухайн сум дүүргийн Засаг даргын болон байгаль орчны хяналтын албаны тодорхойлолт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3 Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан өгч байсан талаарх тодорхойлолт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4 Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5 Талбайг буцаан хүлээлгэж өгөхийг зөвшөөрсөн хувь нийлүүлэгчийн хурлын шийдвэр	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Өргөдөл гаргагч: ..... /  
(Гарын үсэг)

(Нэр) /



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БАРЬЦААЛСНЫГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Огноо: ..... (он/сар/өдөр) Өргөдөл гаргагчийн нэр: ..... (Овог, нэр)

Компанийн нэр: .....

Компанийн регистрийн дугаар:.....

**Тусгай зөвшөөрөл:**

Тусгай зөвшөөрлийн дугаар:.....

**Барьцаа:**

Барьцаалуулсан: .....

Барьцаалах болсон шалтгаан:

.....  
.....  
.....  
.....

**Дараахь баримт бичгүүдийг хавсаргана уу:**

	Өргөдөл гаргагч хавсаргав	Өргөдөл хүлээн авагч хүлээн авав
1 Тусгай зөвшөөрөл, хавсралтууд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2 Тусгай зөвшөөрөл барьцаалах гэрээний нэг хувь	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3 Тусгай зөвшөөрөл барьцаалагч, барьцаалуулагч хуулийн этгээдийн дүрэм, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4 Тусгай зөвшөөрөл барьцаалуулагчийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг барьцаалахыг зөвшөөрсөн тодорхойлолт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5 Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6 Барьцаалагчийн албан ёсны тодорхойлолт (Маягт К-15)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7 Барьцаалуулагчийн албан ёсны тодорхойлолт (Маягт К-16)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тамга

Өргөдөл гаргагч: ..... /  
(Гарын үсэг)

..... /  
(Нэр)